

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
 2024 оны 01 сарын 28 өдрийн
 10 албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	2023 онд манай байгууллагад 243,182.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 240,321.9 мянган төгрөгийг зарцуулж 860.7 мянган төгрөг хэмнэн төсөвт төвлөрүүлсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 17 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	12-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	2023 оны хяналт шалгалтын баримтаа архивлаж архивт хүлээлгэн өгөх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	01 сар	1. Байгууллагын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган батлуулсан. 2. 2023 оны 71 баримтыг архивын нэгж үүсгэсэн.
3	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	01 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 70 хувьтай үргэлжилж байна.
4	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	01 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сум дундын ойн ангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 30 хувьтай үргэлжилж байна.

5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	01 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 11 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 99,3 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 12 хувиар өсчээ.
6	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	01 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 3 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудс https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 56 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
7	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	01 сар	1. Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 6 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. 2. Монгол бичгийн дунд шатны танхимын сургалтад 100 хувь хамрагдаж байна. 3. Төрийн албан хаагчдад зориулсан Удирдлагын академиас зохион байгуулж буй Авлига, Ёс зүй, Монгол бичиг, Хүний эрх, Жендер гэсэн нийт 5 төрлийн тус бүр 3 түвшиний цахим сургалтад сургалтад 100 хувь хамрагдаж үнэмлэх авсан. 4. Сангийн яамнаас “Дотоод аудитын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем” нэвтрүүлэхтэй холбоотой сургалтад 2024 оны 01 дүгээр сарын 3,5-ны өдрүүдэд хамрагдсан

			5. ГБХЗГ-аас зохион байгуулсан Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчидэд зориулсан сургалтад 3 албан хаагч хамрагдсан. 6. 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах тухай" сэдвээр шинээр санхүүгийн албанд томилогдсон болон сонирхсон төрийн албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар -4, Соёл урлагийн газар-1, 2-р сургууль-1, Сүмбэр сумын ЗДТГ-3, Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газар-1, Боржигин чуулга-1, Сум дундын ойн анги-1 нийт 12 албан хаагч хамрагдсан. 7. Монгол улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ойг тохиолдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Нутгийн удирдлагын ордон дахь төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан "Дөрвөн бэрх" тэмцээнд оролцсон. 8. Байгууллагын 5 албан хаагч ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд мэдүүлж ЭБАТ-аар баталгаажуулсан. 9. 2024 оны 1 дүгээр сарын 5, 24-ний өдөр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд хувиарласан талбай болох Аймгийн Засаг даргын Тамгын газрын зүүн талын явган хүний зам, 5 дугаар цэцэрлэг хүртлэх явган замын хуваарьт хэсгийн дагтаршсан цас болон орчны хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт хаясан. 10. Яаралтай тусламж хэрэгтэй үед ашиглах what3words апп-г байгууллагын 6 албан хаагчид утсан дээрээ суулгаж мэдээллийн аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн.
--	--	--	---

				11. Байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлэхээр холбогдох баримт материалыг Төрийн аудитын газарт хүргүүлсэн. 12. Авилгын 2024 оны төлөвлөгөөг гарган даргаар батлуулан байгууллагын веб хуудсанд байршуулсан.
--	--	--	--	---

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг